

## ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОЙРЫН ЗОРИЛТ

### CURRENT SITUATION OF RESEARCH STUDY OF THE LAW ENFORCEMENT UNIVERSITY AND ITS IMMEDIATE OBJECTIVES



#### О.ЗОРИГТ

ХСИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн хурандаа

#### ZORIGT O.

Dean of Research, Law Enforcement University, Ph.D, police colonel

**Товч агуулга:** Энэ илтгэлд Хууль сахиулахын их сургуулийн хөгжлийн чиг хандлага, стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүн, их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үндсэн чиглэл, бүтэц, хэмжээ, чанар, энэ чиглэлийн хамтын ажиллагааны асуудлын талаар товч мэдээлж, өнөөгийн байдлыг үнэлэн ойрын зорилтыг тодорхойлсон байна.

**Abstract:** This research report covers and focuses on the assessments of the current research situation of the Law Enforcement University, particularly, the performances of the main and subsidiary researches, the project implementation, the introduction of innovations, the issue of the research studies of scientists, the international scientific conferences, council for a doctoral degree, theoretical and methodological journals and foreign cooperation by emphasizing the actual problems and formulizing the immediate objectives.

“Хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал-эрдэмтдийн уулзалтад уригдан ирж оролцож буй гадаад, дотоодын хүндэт зочид, төлөөлөгчид, эрдэмтэн, судлаач, профессор багш Та бүхний энэ өдрийн түмэн амар амгаланг айлтган мэндчилье!

Монгол Улсын Хууль сахиулах их сургуулиас жил бүр зохион байгуулдаг уламжлалт олон улсын эрдэм шинжилгээний хурал энэ удаад шинэлэг байдлаар нар хур тэгширсэн дэлгэр зуны улиралд байгалийн сайхан цогцолсон Монгол орны хоймор нутаг үзэсгэлэнт Хөвсгөл нуурын эрэгт зохион байгуулагдаж байгаагаараа онцлог гэдгийг юуны өмнө тэмдэглэн хэлэхийг хүсч байна.

“Мэдээлэл” боломж олгодог, “мэдлэг” хөгжил дагуулдаг гэж үг байдаг. Бид энэхүү хурал-уулзалтаараа Монгол Улсын болон оролцогч орнуудын эрх зүйн шинэчлэл, хууль сахиулах салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, хамтын ажиллагаа, гэмт хэрэгтэй тэмцэх, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гамшгаас сэргийлэх, үр дагаврыг арилгах болон аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудлыг хөндөн хэлэлцэж, харилцан санал, мэдээлэл солилцдог уламжлалтай билээ.

Манай олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогчид “мэдлэг, түүнд суурилсан чадварыг бий болгодог” эрдэм шинжилгээ, боловсролын салбарын

ажилтан, эрдэмтэн, профессор багш, судлаач нар учраас харилцан мэдээлэл, туршлага солилцох явдал бидний ажилд нэн чухал нөлөөтэй төдийгүй байгууллага, салбар, цаашлаад улс орны хөгжилд хувь нэмэр болно гэдэгтэй Та бүхэн санал нэгдэх байх гэж бодож байна.

XXI зуун бол даяаршлын үйл явцын нөлөөгөөр “нэгэнт хавтгай” болсон манай дэлхийд мэдлэгийн эдийн засаг ноёрхох зуун юм. Дэлхийн улс орнуудын эдийн засгийн бүх салбарт шинэ техник, технологи нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх үйл явц эрчимтэй явагдаж байна. Хууль сахиулахын салбар ч энэ үйл явцаас ангид байх боломжгүй.

Тийм учраас би энэ удаад Монгол Улсын Хууль сахиулах их сургуулийн хөгжлийн үзэл баримтлал, чиг хандлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын өнөөгийн байдал, сургалтын арга, технологийг боловсронгуй болгох, суралцах орчин нөхцлийг сайжруулах, эрдэм шинжилгээ судалгааны хамтын ажиллагааг хөгжүүлэх, инновацийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, дэвшүүлж буй ойрын зорилтын талаарх мэдээллүүдэд Та бүхний анхаарлыг хандуулах болно.

Хууль сахиулахын их сургууль анх 1934 онд Дотоод явдлын яамны төв сургууль нэртэйгээр байгуулагдсан Монгол Улсын дээд боловсролын ууган байгууллагуудын нэг бөгөөд өнгөрсөн 80 гаруй жилийн хугацаанд нэр, статус нь 7 удаа өөрчлөгдөж ирсэн арвин баялагтай түүхтэй сургууль билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 87 дугаар тогтоолоор “Хууль сахиулахын их сургууль”-ийг эмхлэн байгуулсан нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын боловсон хүчнийг нэгэн дээвэр дор нэгдсэн бодлого, сургалтын технологиор бэлтгэх, салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын шилдэг мэргэжилтнүүдийн оюуны хүчийг нэгтгэх боломжийг бүрдүүлсэн бодлогын зөв шийдвэр болсон гэж бид үздэг.

Байгуулагдаад төдийлөн удаагүй ч ХСИС-ийн эрдмийн хамт олон судалгааны их сургууль болж хөгжих, шинжлэх ухааны чадавхиа нэмэгдүүлэх, мэргэжлийн өндөр ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх, сургалт судалгааны шинэ технологийг нэвтрүүлэх, хууль сахиулах байгууллагын тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэх, бүс нутгийн хэмжээнд төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, цахим их сургууль болох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэх чиглэлээр цөөнгүй ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

2015 онд “Хууль сахиулахын их сургуулийн дүрэм”, “Хөгжлийн стратеги хөтөлбөр”, “Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө”, “Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стратеги хөтөлбөр”, “Инновацийн хөтөлбөр” зэрэг хөгжлийн бодлогын тулгуур баримт бичгүүдийг боловсруулан баталж, Их сургуулийн ирээдүйн хөгжлийн чиглэл, стратегийн зорилго, зорилтууд, тэдгээрт хүрэх арга зам, шаардлагатай бүтэц, хөрөнгө, үе шаттайгаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойллоо.

ХСИС-ийн дүрэмд их сургуулийн алсын харааг “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль сахиулах үйл ажиллагааны шинжлэх ухаан, боловсрол, үйлчилгээний нэгдлийг хангахуйц инновацийн үр ашигтай тогтолцоог хөгжүүлэх, судалгааны тодорхой чиглэлд тэргүүлэх байр суурьтай, зөвлөх эрхтэй, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, шинжлэх

ухааны хамт олон болох, төлөвших замаар иргэдийнхээ энх амгалан байдлыг сахиулах, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулагч мэдлэг, оюуны төв байх" хэмээн томъёолов.<sup>1</sup>

Хөгжлийн стратеги, зорилгод нийцүүлэн Хууль сахиулахын их сургуулийн бүтцийг шинэчлэн баталснаар ХСИС өнөөдрийн байдлаар Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, Эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн Ажлын алба, 7 бүрэлдэхүүн, 1 харьяа сургууль, сургалт, эрдэм шинжилгээ, албаны зохион байгуулалт, дэмжлэг үзүүлэх чиг үүргийн гэсэн бүтцийн нэгжүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

2014-2015 оны хичээлийн жилийн дүнгээр авч үзвэл их сургуульд мэргэжлийн болон бакалаврын түвшний 3000 гаруй оюутан, 200 гаруй магистрант, 100 орчим докторант суралцаж, 500 гаруй алба хаагч, 180 гаруй багш, түүний дотор 30 гаруй доктор, 30 орчим эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байна.

2015 онд тус Их сургуулийг мэргэжлийн боловсролын түвшинд 6 мэргэжлээр 1000, бакалаврын түвшинд 6 мэргэжлээр 500, магистрын түвшинд 4 мэргэжлээр 150 суралцагч төгсөж, 4 багш, судлаач докторын зэрэг хамгаалжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "судалгаа, шинжилгээний ажлыг их, дээд сургууль болон бодлогын инситут дээр төвлөрүүлж, Шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилтийг энэ зорилготой уялдуулах" гэж заасны дагуу тус сургуульд шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, онол, арга зүй, үр дүнг практикт нэвтрүүлэх, их сургууль, салбарын хөгжилд шинжлэх ухааны үндэслэлтэй дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Эрдэм шинжилгээ хөгжлийн хүрээлэнг Цагдаа, Хил, Шинжлэн магадлахуй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, Гамшгийн эрсдэл судлалын төв болон Хууль сахиулахуйн инновацийн төв гэсэн бүтэцтэйгээр байгуулан ажиллаж байна.

Мөн хууль сахиулах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх явдал их сургуулийн эрхэм зорилгын нэг заалт болж орсонтой холбогдуулан эрдэм шинжилгээний хүрээлэн, бүрэлдхүүн болон харьяа сургууль, тэнхимд түшиглэн Гэмт явдал судлал, Цагдаа судлал, Гэмт хэрэг илрүүлэхүйн ухаан, Мэдээллийн аюулгүй байдал судлал, Шинжлэн магадлахуйн ухаан, Замын хөдөлгөөний аюулгүй байдал судлал, Ахлагч мэргэжил судлал, Албаны бэлтгэл зүй, Хууль сахиулахуйн боловсрол судлал зэрэг 17 чиглэлээр профессорын судалгааны багуудыг шинээр байгуулан үйл ажиллагаанд нь мөрдөх журмыг батлан ажиллуулж эхлээд байна.

Зохион байгуулалтын энэхүү арга хэмжээний үр дүнд их сургуулийн хэмжээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажил шинжлэх ухааны тухайн салбар, чиглэлээр мэргэшсэн судлаачдаас бүрдсэн профессорын судалгааны багуудад түшиглэн явагдаж чанар, үр өгөөж нь дээшлэнэ гэж үзэж байна.

Түүнчлэн, Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх, шинжлэх ухааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх, инновацийн бодлогыг хэрэгжүүлэх, их сургууль үйлдвэрлэл эрхлэх, ингэснээр эрдэмтэн, судлаачдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, багшийг хөгжүүлэх,

<sup>1</sup> Хууль зүйн сайдын 2012 оны А/85 дугаар тушаалаар баталсан "Хууль сахиулахын их сургуулийн дүрэм"-ийн 1.5 дахь заалт

оюутны суралцах орчныг сайжруулах зорилгоор Их сургуулийн дэргэд “Гарааны компани байгуулан ажиллуулах” шийдвэрийг өнгөрсөн 6 дугаар сард болсон Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаас гарган хэрэгжүүлж байна

Аливаа их сургуулийн нэг үнэт зүйл бол багш, судлаач, эрдэмтэд, тэдний эрдмийн бүтээлүүд юм. ХСИС-ийн профессор, багш нар өнгөрсөн хичээлийн жилд 10 сурах бичиг, 15 нэг сэдэвт бүтээл, 30 гаруй гарын авлага, 10 орчуулгын бүтээл, 20 эмхэтгэл бэлтгэн гаргаж, 10 багш гадаадын, 100 гаруй багш дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл, бүтээлээ нийтлүүлсэн байна. ХСИС-ийн хэмжээнд “Хууль сахиулахуй”, “Хууль сахиулахуйн удирдлага”, “Цагдаа судлал”, “Хил судлал”, “Эрдмийн бичиг”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал”, “Гамшиг судлал”, “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн нийт 8 сэтгүүлийг тогтмол эрхлэн гаргаж, эрдэмтэн, багш, судлаачдын оюуны бүтээл, санааг олон нийт, хууль сахиулах байгууллагын практик ажилтнууд, оюутан суралцагсдад түгээж байна.

Эрдэмтэн, судлаач, профессор, багшийн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг бодит шаардлага, эрэлтэд нийцүүлэх, тэнхим, профессорын судалгааны баг, сургуулийн түвшинд хянан шүүх ажлыг чанаржуулах асуудлыг зохицуулсан “Их сургуулийн хэвлэл редакцийн журам”-ыг батлан гаргалаа. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанар үр дүнд шууд нөлөөлөх нэг хүчин зүйл бол багш, судлаачдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх явдал юм. Өнөөдөр ХСИС-д Гадаад хэлний тэнхим, Гадаад хэлний сургалтын баг ажиллаж багш, суралцагсдад англи, орос, солонгос, герман хэлний сургалтыг онлайн болон зайны сургалт хэлбэрээр явуулж байна. Түүнчлэн, багш, судлаачдад чиглэсэн тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж, англи, орос, хятад, солонгос, герман хэл эзэмшүүлэх, академик түвшний бүрэн мэдлэгтэй болгоход онцгойлон анхаарч эрдэм шинжилгээний ажилтан, багш, судлаач бүр 1-ээс доошгүй гадаад хэлийг мэддэг байх шаардлага тавин ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 4 дүгээр сарын 25-ны А/168 дугаар тушаалаар ХСИС-д Хууль сахиулахын докторын зэрэг хамгаалуулах зөвлөл анх байгуулагдаж, зөвлөлийг Монгол Улсын эрх зүйн салбарын хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй академич Ж.Амарсанаа удирдан ажиллах болсон нь шинжлэх ухааныг хөгжүүлэх, ХСИС-ийн багш, судлаачдын шинжлэх ухааны чадамжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой ажил боллоо.

Саяхан бид “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийг шинэчлэн хамгаалах үйл ажиллагааны зохицуулалтыг илүү тодорхой, ойлгомжтой болгосноос гадна гадаадын судлаач, горилогчид манай их сургуульд эрдмийн зэрэг хамгаалах боломжийг нээсэн заалт шинээр орсоныг зориуд тэмдэглэн хэлэхийг хүсч байна.

Тус Их сургууль их сургуулийн статустайгаар үйл ажиллагаа явуулж эхэлсэнээс хойш жил бүр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж ирсэн. 2011 онд “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал”, 2012 онд “Хилийн аюулгүй байдал, хамтын ажиллагаа”, 2013 онд “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага”, 2014 онд “Хууль сахиулахуйн инноваци” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг тус тус амжилттай зохион байгуулсан билээ.

Хууль сахиулахын их сургуулиас зохион байгуулж ирсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлуудыг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, ХЗЯ, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Нээлттэй нийгэм форум зэрэг олон байгууллага хамтран

зохион байгуулж, дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид өргөнөөр оролцож ирсэн. Бид цаашид олон улсын эрдэм шинжилгээний хурлаа “Хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа” ерөнхий сэдвээр жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр хурлаар хэлэлцэх асуудлын хүрээ оролцогчдод тодорхой байх, хамтын ажиллагааны асуудлууд гүнзгий судлагдах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүний зэрэгцээ тухайн жилд аль нэг бүлэг асуудлыг сонгон хэлэлцэх боломж нээлттэй хэвээр байна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Энэ удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлаар хууль сахиулах байгууллага, ялангуяа орон нутгийн хууль сахиулах байгууллага, түүний дотор хил орчмын нутаг дэвсгэрийн хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны талаар голлон хэлэлцэх гэж байна. Энэ дашрамд оролцогчдоос хурлын сэдэв тогтмол байх асуудлаар байр сууриа илэрхийлж, санал солилцохыг хүсч байна. Мөн бид цаашид олон улсын эрдэм шинжилгээний хурлыг өнөөдрийн жишгээр орон нутагт зохион байгуулж байх бодлого баримтлах болно. Тухайлбал, ирэх жил бид Монгол орны зүүн хязгаар нутаг Дорнод аймгийн нутаг Буйр нуурын эрэгт зохион байгуулахаар бодож төлөвлөж байна.

Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн нь багш, эрдэмтэн, судлаачидтай хамтран ХЗЯ, ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ болон бусад агентлаг, төрийн байгууллагын захиалга, Их сургуулийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд жилд 15 орчим суурь болон хавсарга судалгааны ажил гүйцэтгэж ажилласан байна. Түүнчлэн, суурь болон захиалгат 5 судалгааны төслийн баримт бичиг боловсруулж, Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжилт авахаар ХЗЯ-нд хүргүүлжээ.

Цаашид Их сургуульд хууль сахиулах байгууллагын захиалгаар шинжилгээ, судалгаа хийдэг эрдэм шинжилгээний бүтэц, тухайлбал, гарын мөрний адилтгалын автомат систем “Папилон”, ДНК-ийн шинжилгээний болон дүрс, авиа судлалын лаборатори, нөхцөл байдлын шинжилгээний лаборатори, полиграфологийн төв, гамшиг судлалын болон хил хамгаалах техник зүйн лаборатори, профайлингийн кабинет зэргийг байгуулах арга хэмжээг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Их сургуулийн эрдэмтэн, багш, судлаачид нь хууль сахиулах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх үйлсэд хүчин зүтгэхийн зэрэгцээ хууль боловсруулах үйл ажиллагаанд идэвхитэй оролцож ирсэнийг дурдахгүй өнгөрч болохгүй. Монгол Улсад хэрэгжиж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд сүүлийн 3 жилд батлагдсан гол гол хууль, эрх зүйн бусад баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдхүүнд Их сургуулийн 20 гаруй эрдэмтэн багш орж ажилласнаас гадна 30 орчим эрх зүйн баримт бичигт дүгнэлт гарган ажиллажээ.

Тухайлбал: Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль зэргийг дурдаж болно.

Сургалтын агуулга, хэлбэр, технологийг шинэчлэх, олон улсын жишигт сургалтын агуулга, стандартыг нийцүүлэх зорилтын хүрээнд дотоод, гадаадын их

сургуультай хамтран ажиллах, зочин профессор урьж ажиллуулах, илгээх, багш-судлаач-суралцагч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Цаашид сургалтын мэргэжлийн тоог нэмэгдүүлж гааль, мэргэжлийн хяналт, татвар, улсын бүртгэл, гадаадын иргэн, харьяатын зэрэг хууль сахиулах бусад байгууллагын ажилтнуудыг сургаж бэлтгэдэг болох зорилт тавин ажиллаж байна.

Академик сургалтыг прагматик сургалтын хэлбэрт шилжүүлэх зорилгоор сургалтын клиникүүдийг ХСИС-ийн бүтцэд бий болгох ажил явагдаж байна. “Клиник сургалтын төв”-үүдийг төрөл, мэргэжлийн онцлогтой холбоотойгоор хэд хэдэн чиглэлээр зохион байгуулна. Жишээлбэл, “Хууль зүйн клиник төв”, “Цагдаагийн клиник кобан”, “Замын цагдаагийн клиник пост”, “Аврах, гал унтраах клиник анги” зэргийг Их сургуулийн хотхонд байгуулахаар төлөвлөж байна.

Онолын мэдлэгийг бататгах, ур чадвар олгох, дэг журам, ёс зүйтэй байх, мэргэжлийн үнэт зүйл, хандлага төлөвшүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр Гачууртын “Гүнжийн хоолой”-д Сургалт-дадлагын цогцолбор байгуулан, сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Бүсийн давтан сургалтын төвүүдийг байгуулах бөгөөд эдгээр төвүүд нь алба хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг мөн зохион байгуулсан бөгөөд бүсийн давтан сургалтын төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлага байна.

Сургалтын арга технологийг боловсронгуй болгохоос гадна сургалтын орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд ХСИС-ийг кампус хэлбэрээр хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлагдаж энэ төлөвлөгөөний хүрээнд 850 оюутны дотуур байр баригдаж ашиглалтад ороод байгаа бөгөөд 3000 сонсогчийн хичээлийн байрыг ирэх 9 сард ашиглалтад оруулахаар барилгын ажил явагдаж байна.

Хууль сахиулахын их сургууль сонгодог их сургуулийн жишгээр амжилттай хөгжихөд эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын гадаад харилцаа, хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой. Иймд Их сургууль энэ чиглэлийн үйл ажиллагааг идэвхтэй өргөжүүлэн хөгжүүлэх бодлого, зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар Их сургууль ОХУ-ын Дотоод хэргийн яамны Дорнод Сибирийн дээд сургууль, Буриадын Улсын их сургууль, Томскийн Багшийн их сургууль, БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалахын их сургууль, Канад Улсын Британий колумбын эрх зүйн институт, Тайланд Улсын Онцгой байдлын сургууль, БНСУ-ын Кёонги ихсургууль, Сёжон их сургууль, БНТурк Улсын Үндэсний Цагдаагийн академи, ОХУ-ын Ял эдлүүлэх албаны Эрх зүй, удирдлагын академи, Солонгосын Криминологийн Холбоо, ХБНГУ-ын Макс Планкын институт зэрэг сургалт,судалгааны 11 байгууллагатай идэвхтэй хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурж, хамтран ажиллаж байна.

Санамж бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Их сургуулийн албан хаагчдаа гадаад орон болон олон улсын байгууллагын шугамаар зохион байгуулагдсан мэргэжлийн сургалт, семинар, олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцуулах, гадаад орны ижил төстэй чиг үүрэг бүхий сургалтын байгууллагад айлчилж туршлага судлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тус Их сургуулиас гадаад айлчлал, олон улсын сургалт, туршлага судлах, зочин судлаачаар ажиллах, оюутан солилцооны хөтөлбөрт жилд дунджаар 100 гаруй багш, багш, албан хаагч, сонсогчид хамрагддаг.

Хууль сахиулах чиг үүрэг бүхий олон улсын байгууллагуудтай харилцаа

хамтын ажиллагааг хөгжүүлэхээр Цагдаагийн сургуулиудын олон улсын холбоо (INTERPA), Засан хүмүүжүүлэх ба хорих байгууллагын олон улсын холбоо (ICPA), Криминологчдын олон улсын холбоо (ICA), Цагдаагийн байгууллагын дарга нарын олон улсын холбоо (IACP), Бээжин хотод суугаа гадаад орны хууль сахиулах байгууллагын атташе нарын холбоо (FLECC), Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (OSCE) зэрэг байгууллагатай харилцаа тогтоож эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр хамтарч ажиллаж байна.

Мөн Монгол Улсад суугаа ХБНГУ, АНУ, БНХАУ, БНТУ, ОХУ, Канад, Кувейт, Япон, Франц Улс, БНЧех Улс, БНКазахстан Улсын элчин сайдын яамны төлөөлөл болон ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, АНУ-ын Азийн сан, НҮБ-ын Хүн амын сан (UNFPA), Хүүхдийн сан (UNICEF), Ази болон Алс дорнодын Хүрээлэн (UNAFEI), Туркийн олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн агентлаг (TISKA), Солонгосын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (KOICA), Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр (UNDP), Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA), Азийн хөгжлийн банк (ADB) зэрэг олон улсын байгууллагатай хамтарч ажиллан үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд бодлого баримтлан ажиллаж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын эрх зүйн болон хууль сахиулах салбарын шинжлэх ухааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулж ирсэн ОХУ-ын ДЯЯ-ны Удирдлагын академийн профессор, ОХУ-ын ШУА-ийн академич, гавъяат хуульч, доктор Аتماжитов.В.М., ОХУ-ын ДЯЯ-ны Москвагийн их сургуулийн профессор, ОХУ-ын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, гавъяат хуульч, доктор Майлис Н.П. нарт Хууль сахиулахын их сургуулийн “Хүндэт профессор”, ХБНГУ-ын Макс Планкийн гадаадын болон олон улсын эрүүгийн эрх зүй, криминологийн хүрээлэнгийн захирал Ханнс Йорг Альбрехтад Хууль сахиулахын их сургуулийн “Хүндэт доктор” цол тус тус олгох тухай асуудлыг 2017 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн.

Гадаад улсын хамтын ажиллагааны зэрэгцээ дотоод хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлж байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн яам, түүний харьяа агентлагууд, онцгой байдлын алба, Боловсрол, шинжлэх ухааны яам, Шинжлэх ухаан, технологийн сан, Шинжлэх ухааны академи, тэдгээрийн хүрээлэнгүүд, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Стратеги судалгааны хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн зэрэг мэргэжлийн томоохон хүрээлэн, МУИС, ШУТИС, МУБИС, БХИС, ХААИС зэрэг их, дээд сургууль, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Нээлттэй нийгэм форум зэрэг олон улсын байгууллага, төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, инновацийг нэвтрүүлж буй аж ахуйн нэгж, байгууллага, эрдэмтэн, судлаачидтай нягт хамтын ажиллагаатай ажиллаж байна. Саяхан Монгол Улсын тэргүүлэх их сургуулиудын нэг болох ШУТИС-тай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан.

Түүнчлэн, хууль сахиулахын их сургуулийн багш, оюутан, магистр, докторантуудад Монгол Улсын нэрт эрдэмтэн доктор, академичдаар лекц уншуулах, тэдэнтэй уулзалт зохион байгуулах, зөвлөгөө сургамж өгүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Ингээд илтгэлийнхээ үндсэн хэсгийг төгсгөж дүгнэн хэлэхэд ХСИС-ийн эрдмийн хамт олон цаг үеийн шаардлага, хөгжлийн чиг хандлагадаа нийцүүлэн шинжлэх ухааны чадавхиа нэмэгдүүлэх, өндөр ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх, хууль сахиулах байгууллагын тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй

шийдвэрлэхэд тодорхой үүрэгтэй оролцох, бүс нутгийн хэмжээнд төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, судалгаанд суурилсан цахим их сургууль болж хөгжих үндсэн зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж тодорхой үр дүнд хүрч байна.

Хөгжлийн чиг хандлага, зорилго, зорилт, алсын хараа, эрхэм зорилгоо шинээр томъёолж, түүнд нийцсэн бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог бий болгож, сургалтын орчин нөхцлийг сайжруулахад шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэсэн, их сургуулийн гадаад, дотоод хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, инновацийн хөтөлбөр баталсан, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, шинэ техник, бүтээгдхүүн үйлдвэрлэх гарааны компани байгуулсан зэрэг зарим ололт, амжилт байгаа хэдий ч анхаарч ойрын зорилт болгон шийдвэрлэх шаардлагатай дараах асуудлууд байна.

Юуны өмнө эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн хэв шинжит их сургуулийн хувьд шинжлэх ухааны салбар бүрээр суурь судалганы бүтээлүүд бий болгоход эрдэм шинжилгээ судалгааны ажлыг чиглүүлж, багш судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх бодит хөшүүрэг, дэмжлэгийг бий болгох шаардлагатай байна.

Мөн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх гарц, боломжийг бий болгох, судалгаа шинжилгээ явуулах төрөлжсөн лаборатори, дадлагын кабинет байгуулах, багш судлаачдын бүтээлийн чанар, сургалтын гарын авлага, сурах бичгийн хүрэлцээг сайжруулах, суралцагсад цахим хэлбэрээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх, Их сургуулийн үйл ажиллагааг бүхэлд нь цахим технологид бүрэн шилжүүлэх, эрдмийн зэрэг цолтой багш, ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлийн хамтын ажиллагааны хэлбэр, хүрээг өргөжүүлэх, бүс нутаг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын туршлагыг судалж нэвтрүүлэх ажлыг ойрын хугацаанд зохион байгуулах шаардлагатай байна.

Түүнчлэн, хууль сахиулах боловсролын хөгжлийн шинэ чиг хандлагыг бий болгон хэвшүүлэхийн тулд сургалтын чиглэлийг өргөжүүлэн агуулгыг нь гүнзгийрүүлэхийн сацуу, үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах албаны онцлогийг харгалзсан “хаалттай”, хүний нөөцийн зах зээлийн эрэлтэд чиглэсэн “нээлттэй”, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн шударга ёсыг тогтоох хандлагыг төлөвшүүлэх “иргэншсэн”, албаны шуурхай бэлэн байдлыг хангах, тусгай чиг үүрэг гүйцэтгэх онцлогт нийцүүлсэн “цэрэгжсэн”, их сургуулийн санхүү, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх “төлбөртэй”, “төлбөргүй” зэрэг хосолсон сургалтын системийн хувилбарыг зөв сонгон авч, оновчтой хэрэгжүүлэх явдал Их сургууль амжилттай хөгжиж, хэтийн зорилгодоо хүрэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.